



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 07 сарын 17 өдөр

Дугаар А/510

Булган сум

Гүйцэтгэгчид гэрээ байгуулах  
эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хуралдааны 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн XIX/08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгаль хамгаалах сангийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгасан "Тэрбум" мод үндэсний хөдөлгөөний хүрээнд цөлжилт элсний нүүдлээс хамгаалах зурвасын ажил (12 га, Рашаант-3 га, Баяннуур-3 га, Гурванбулаг-3 га, Дашинчилэн-3 га), 2 дугаар багц Гурванбулаг сумын Хулст баг сумын төвийн зүйн хойд талд 3 га талбай, Рашаант сумын "Улаан шивээт" сумын төвөөс 1 км газарт 3 га талбай, улсын чанартай авто замын дагуу нийт 6 га талбайд ойн зурвасын ажлыг хийх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерт шалгарсан "Хөвөнтөн-Ой" ХХК-тай 88 000 000 (наян найман сая) төгрөгөөр гэрээ байгуулах эрхийг Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга (А.Гантөмөр)-д олгосугай.

2. Ажлын гүйцэтгэлд холбогдох хууль, тогтоомж, гэрээний дагуу хяналт тавьж, хүлээн авахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга (А.Гантөмөр)-т даалгасугай.

3. Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль, журам, стандартын дагуу гүйцэтгэж, хүлээлгэн өгөхийг "Хөвөнтөн-Ой" ХХК-ийн захирал (Ч.Оюун)-д үүрэг болгосугай.

4. Тус ажлын санхүүжилтийг холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч (Б.Бумцэнд)-д зөвшөөрсүгэй.


5. Хөрөнгийг данс бүртгэлд тусгаж ашиглалт, хадгалалт, хамгаалалтанд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга (А.Гантөмөр)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ

6324010871

Аймгийн Засаг даргын 2024 оны  
07 дугаар сарын 17-ны өдрийн  
А/510 дугаар захирамжийн хавсралт



Д/д	Нөхцөл шаардлага	Мөнгөн дүн	Хариуцах албан тушаалтан
1	2	3	4
1	Алданги	Хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.1 хувь байна. Нийт алдангийн хувь гүйцэтгээгүй үүргийн 10 хувиас хэтрэхгүй байна	Д.Батцогт
2	Чанарын баталгаа	Гэрээний үнийн дүнгийн 5 хувь	А.Гантөмөр